



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 09 өдөр

Дугаар A/180

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 6.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, эм зүйн албаны үйл ажиллагааг тушаалын дагуу зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн хэвшлийн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/-т даалгасугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ

080684



Эрүүл мэндийн сайдын 2016 оны
12 дугаар сарын 109.-ны өдрийн
180 дугаар тушаалын хавсралт

ЭМНЭЛГИЙН ЭМ ЗҮЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эмнэлгийн эм зүйн албаны /эмийн сан/ бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлох, эм зүйн тусlamж үйлчилгээг багаар үзүүлж, эмнэлгийн тусlamж үйлчилгээнд эмийн эмчилгээний үр дүнг хянах, чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2 Энэхүү дүрмийг эмнэлгийн эм зүйн албанд мөрдөнө.
- 1.3 Эм зүйн алба нь Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр хянах, эмнэл зүйн эм зүйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулна.
- 1.4 Монгол улсын “Эрүүл мэндийн тухай”, “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хууль, “Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2014” стандарт, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 32 тоот тушаалаар батлагдсан “Эм зүй, эм найруулагчийн ёс зүйн хэм, хэмжээ эрх, үүрэг” болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

Хоёр. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Эм зүйн албаны бүтэц, зохион байгуулалт нь “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015” стандартын шаардлага, эмнэлгийн тусlamж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчилгээний тухай, эм зүйн тусlamж үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг хангасан байна.
- 2.2. Эм зүйн алба нь мэргэжлийн тусlamж үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий багаас бүрдэнэ. Үүнд:
 - 2.2.1. Менежментийн баг: Тухайн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны онцлогоос хамаарч уг багийг бүрдүүлнэ. Эм зүйн албаны дарга, эм шинжлэгч, нөөцийн тасгийн эм зүйчээс бүрдэх энэхүү баг нь эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт болон эмнэл зүйн эм зүйн тусlamж үйлчилгээ, холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу эм зүйн албаны үйл ажиллагааг хянах, үйл ажиллагаанд тулгамдаж буй хүндрэлтэй асуудлыг тогтоох, сайжруулах арга хэмжээг төлөвлөх үүргийг хүлээнэж, гаргасан шийдвэрийг баримтжуулна. Эм зүйн албаны дарга эмнэлгийн эм зүйн тусlamжийн үйл ажиллагаанд бүхэлд нь хариуцлага хүлээнэ. Эм зүйн албаны дарга эмнэлгийн менежментийн багийн гишүүнээр ажиллана.
 - 2.2.2. Мэргэжлийн баг: Эм зүйн тусlamж үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн эм зүйчдээс бүрдэнэ. Энэхүү баг эмийн хангамж болон эмнэл зүйн эм зүйн тусlamж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бүх үйл ажиллагааг гүйцэтгэх, эмийн зөв

зохистой хэрэглээ, эмийн эмчилгээний сонголтыг эмчийн багтай хамтран хийх, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд тавих дотоод хяналтыг хариуцах, туслах ажилтнуудын үйл ажиллагааг хянах, судалгаа шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах үүрэг хүлээнэ.

- 2.2.3. Дэмжих баг: Эм найруулагч болон бусад туслах ажилтан хамрагдана. Энэхүү баг менежментийн болон мэргэжлийн багаас тодорхойлсон үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ. Эм найруулагч эм, эмнэлгийн хэрэгслийг хянах, тасгийн нөөцийг хянах, нэгж тунгийн системээр эмийг савлах, хаяглах, олгох болон эмийг найруулах үйл ажиллагаанд оролцно. Бусад туслах ажилтан цэвэрлэгээ үйлчилгээг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 2.3. Эм зүйн алба нь эм зүйн тусламж үйлчилгээнд шаардагдах стандарт ажиллагааны зааврыг боловсруулан мөрдөж ажиллана.
- 2.4. Эм зүйн албаны төлөөлөл эмнэлгийн Эмийн эмчилгээний зохицуулах хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах ба тусламж үйлчилгээнд чанартай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангах, эмийг зөв зохистой хэрэглэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.5. Эм зүйн албаны төлөөлөл эмнэлгийн чанарын алба болон холбогдох бусад ажлын хэсэгт орж ажиллана.

Гурав. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа

Эм зүйн алба эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах, эмнэлгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дараах чиглэлээр ажиллана.

3.1 Худалдан авах ажиллагаа

- 3.1.1 Худалдан авах ажиллагааг мэргэжлийн түвшинд ил тод, хууль тогтоомжид нийцсэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйтэй, үнэн зөв найдвартай мэдээллийн систем ашиглан цаг хугацаанд нь үр ашигтай явуулна.
- 3.1.2 Эм зүйч эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах үйл ажиллагаанд биечлэн оролцож аюулгүй, чанартай, эмчилгээний өндөр идэвхтэй эмээр эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хангахад дэмжлэг үзүүлнэ.

3.2 Эмийг хадгалах, түгээх, олгох

- 3.2.1 Эм зүйн албаны мэргэжлийн болон дэмжих баг нь эмийн хадгалалт, түгээлт болон олголтод хариуцлага хүлээж, "Эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, түгээлтэд тавих ерөнхий шаардлага" MNS 5530:2014 стандартын шаардлагыг мөрдөж ажиллана.
- 3.2.2 Эм зүйн албаны ажилтан бүр эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмийн тасалдал үүсэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, яаралтай тохиолдолд шаардлагатай эмээр хангаж ажиллана.
- 3.2.3 Нийлүүлэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн тоо ширхэг, цувралын дугаар, чанарын баталгаажилтыг шалган орлогын бүртгэлд бүртгэж, нөөцийн агуулахад эмх цэгцтэй хадгалах, савлаж бэлдсэн эмийг тасагт хүргэх,

өвчтөний хэрэглээний явц, байдалд хяналт тавьж баримтжуулах үүргийг мэргэжлийн багийн эм зүйчид хариуцан ажиллана.

- 3.2.4 Нөөцийн тасаг нь эмийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын зөв горим дэглэмийг баримтлан эмийн хугацаа дуусах, чанар байдал өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлнэ.
- 3.2.5 Тухайн эмнэлэг өөрийн бүтэц үйл ажиллагааны онцлогоос хамаарч эм түгээх, олгоход дараах системийг дангаар нь болон хослуулан хэрэглэнэ.
- 3.2.5.1 Эмийн нөөц, агуулах, нөөц дүүргэлтийн систем: Яаралтай байдалд өвчтөний амь насыг авран хамгаалах зорилгоор тасаг бүрт шаардлагатай эм бэлдмэлийг нөөцөлнө. Ердийн тохиолдолд тасгийн захиалгаар эм бэлдмэлүүдийг нөөц агуулахаас хуваарилна.
- 3.2.5.2 Тусгай эм, эмийн бэлдмэлийн захиалгын систем: Тухайн өвчтөнд бичсэн эмчийн заалт, жорын дагуу эмийг түгээнэ.
- 3.2.5.3 Нэгж тунгийн олголтын систем: Эм бэлдмэлийг өвчтөн бүрт зориулан нэгж тунгаар зориулалтын машинаар болон гараар савлан хаяглаж олгоно. Савласан эмийг тасаг бүрт хүргэх, өвчтөн эм хэрэглэх асуудлыг сувилагч хариуцаж, өвчтөнд хэрэглэсэн болон эмийн сан руу буцаах эм бэлдмэлийн цувралын дугаар, хаягжилт зэргийг тодорхойлж баримтжуулна.
- 3.2.5.4 Цахим эм олголтын систем: Өвчтөн бүрт тохирсон нэгж тунгаар хуваарилах үйл ажиллагааг цахим системд тулгуурлан гүйцэтгэнэ.
- 3.2.5.5 Цахим жор: Эмч жорыг эм зүйн алба руу цахим жорын системээр дамжуулан илгээнэ.
- 3.2.6. Эм зүйн албаны ажилтан бүр эмийн түгээлтэд гарах аливаа эрсдлээс сэргийлэх, эмийн чанар, аюулгүй байдалтай холбоотой асуудал үүссэн тохиолдолд эмийг эргүүлэн татах боломжийг бүрдүүлэх зорилгоор эмийг хянах системийг хэрэгжүүлнэ.
- 3.2.7. Эм зүйч эмчилгээний эхний тунг өвчтөнд хэрэглэхийн өмнө бүх эм бэлдмэлийг олгосон болон нэмж захиалах эсэхийг эмийн эмчилгээний хуудсыг ашиглан хянана.
- 3.2.8. Тухайн үеийн эмчилгээг өдөр тутам хянахдаа: эмийн бүртгэлийг хөтлөх, үйлчлүүлэгч бүрт олгосон, хэрэглэсэн болон буцаагдсан эмийн тоо хэмжээг харьцуулан хянах замаар хэрэгжүүлнэ.

3.3. Агуулах ба тасгийн хяналт шалгалт

- 3.3.1. Эмийн тээвэрлэлт, тусгай хадгалалтын горим, хугацаа, эм хадгалж буй орчинд хяналт тавина.
- 3.3.2. Хяналтын явцад илэрсэн аливаа зөрчлийг засах арга хэмжээг төлөвлөн ажиллана.

3.4. Хяналттай олгох эмийг хадгалах, түгээх, олгох

- 3.4.1. “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай хууль” болон Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 тоот тушаалаар батлагдсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох,

үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” журмыг мөрдөж ажиллана.

- 3.4.2. Хяналттай олгох эмийн бэлдмэлийг тусгай зориулалтын өрөө, тасалгаанд цоожтой шүүгээнд хадгалж тасгуудын хуваарилалтанд хяналт тавина. Эмийн захиалга, эм хүлээн авах, хуваарилах, хэрэглэх, эмийн хаягдалтай холбоотой бүртгэлийг хөтлөн эм, бэлдмэл тус бүрийн нэгжид хяналт тавина.
- 3.4.3. Хяналттай олгох эмийн өдөр тутмын бүртгэлийн дагуу шалган, зөрчил, алдааг тухай бүрт залруулан холбогдох арга хэмжээг авна.
- 3.4.4. Эм зүйч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээнд давхар хяналт тавьж, хариуцсан ажилтан гарын үсэг зурж баримтжуулна.
- 3.4.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм хадгалах байранд нэвтрэх эрхтэй хүмүүсийн тоог хязгаарлана.
- 3.4.6. Эм зүйч нь эмчлүүлэгчийн эмчилгээний түүхийг шалгаж эмийг зохистой хэмжээнд хэрэглэж байгаа эсэхийг нягтлахын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд эмчилгээ хийсэн эсэхийг лавлана.
- 3.4.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг түгжээтэй саванд хийн битүүмжит байдлыг чандлан тасаг руу зөөвөрлөнө.
- 3.4.8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм хадгалах тусгай хайрцаг олгож ямар зориулалтаар, хичнээн ширхэг эм хэрэглэсэн тухай тэмдэглэл хавсаргаж өдөр бүр ажлын төгсгөлд тус эмийн хайрцгийг хавсралтын хамт эм зүйн албанд хүлээлгэн өгнө.
- 3.4.9. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн нөөцийг өдөр бүр шалгаж, бүртгэлд төрөл, тоо, ширхэгийг нягтлан бүртгэнэ.

3.5. Эм найруулах, бэлтгэх

- 3.5.1. Эм найруулах, бэлтгэх өрөө нь эм зүйн болон эрүүл ахуйн стандартын шаардлага, аюулгүй байдлыг хангасан байна.
- 3.5.2. Эм найруулагч тухайн ээлжийн эмчилгээнд зориулж эмийг найруулах, дахин савлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 3.5.3. Эм найруулагч нь зохих стандарт арга ажиллагааны зааврын дагуу эмийг найруулж бэлтгэн, эм шалгагчид хянуулан, баталгаажуулсны дараа тасгуудад хүлээлгэн өгнө.
- 3.5.4. Эс хордуулах болон хортой эмийг бэлтгэж, найруулахад стандарт үйл ажиллагааны зааврыг мөрдөнө.

Дөрөв. Эмнэл зүйн эм зүйн тусламж, үйлчилгээ

4.1 Эмийн эмчилгээнд хариуцлага хүлээх

- 4.1.1 Эмчлүүлэгчийн эмийн эмчилгээ, эмийн үл нийцэл, харшил, эсрэг заалт, урьд өмнө тохиолдож байсан гаж урвал болон бусад мэдээллийг өвчний түүхийн холбогдох хэсэгт бүртгэсэн эсэхэд эмнэлзүйн алба, чанарын албатай хамтран хяналт тавина.
- 4.1.2 Эмийг эмчлүүлэгчид тараахаас өмнө хүлээн авсан цаасан болон цахим жорын хяналт, үнэлгээг хийнэ.

- 4.3.7 Эмч төлөөлөгчийн газраас эмнэлэгт тодорхой бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөх хүсэлтэй байгаа бол урьдчилан Эм зүйн албатай зөвшилцөнө.
- 4.3.8 Эм зүйн алба эмийг зах зээлд таниулах материалтай урьдчилан танилцаж, эмийг түгээх талаар зохих шийдвэр гаргана.

4.4 Эмнэл зүйн туршилтанд оролцох

Хэрэв тухайн эмнэлэг эмнэл зүйн туршилтанд оролцох бол дараах зарчмыг баримтлана.

- 4.4.1 Эмийн эмчилгээний хороо, эм зүйн алба туршиж байгаа эмийг аюулгүй хэрэглэх журмыг хамтран боловсруулж, мөрдөх асуудлыг хангах ба уг журам нь эмнэл зүйн туршилттай холбоотой хууль тогтоомжинд нийцсэн байна.
- 4.4.2 Эм зүйч эмчлүүлэгчээс туршиж буй эмийн эхний тунг хэрэглэхээс өмнө таниулсан зөвшөөрлийг танилцуулах байдлыг хангана.
- 4.4.3 Эм зүйн алба эмнэл зүйн туршилтанд хэрэглэх эмийн дээжийг хүлээн авах, хадгалах, түгээх асуудлыг хариуцна.
- 4.4.4 Эмнэл зүйн туршилтанд хэрэглэх дээжийг хүлээн авах, хадгалах, түгээх журмыг судалгааны аргачлалтай танилцсаны дараа боловсруулна.